

СЭТГЭХ ЧАДВАРЫН НАМРЫН СОРИЛГО - 2018

Монгол Улсын Оюуны чадварын IQ төв нь эрхэм сурган хүмүүжүүлэгчид та бүхэнтэй хамтран “Сэтгэх чадварын намрын сорилго”-г 11 дэх удаагаа “Логик сэтгэлгээ” сэдвийн хүрээнд орон даяар зохион байгуулж байна.

Монгол хүүхдийн оюуны чадварыг бага наснаас нь хөгжүүлж, оюуны өндөр чадвартай сурагч, багачуудыг илрүүлэх, чадварыг нь баталгаажуулах, оюун ухааныг дээдлэн, дэмжин хөгжүүлэх үзэл санааг түгээн дэлгэрүүлэх эрхэм зорилготой намрын сорилгыг дэмжиж хамтран зохион байгуулна гэдэгт итгэж байна.

Сорилго нь 2018 оны 10-р сарын 24-ны лхагва гарагт улс орон даяар нэгэн зэрэг зохион байгуулагдана. Оюун ухааныг эрхэмлэн дээдэлдэг эрхэм багш, сурагчид та бүхнийг сорилгод идэвхтэй оролцож, оюуны тэнхээгээ сорихыг хүсье.

Намрын сорилгын зохион байгуулалт

1. Сэтгэх чадварын намрын сорилгод ЕБС-ийн I-IX ангийн сурагчид оролцох бөгөөд анги тус бүрээр нийт 9 ангиллаар явагдана. /Энэхүү сорилго нь нээлттэй тэмцээн тул ерөнхий боловсролын ямар ч сургууль оролцох боломжтой/. Сорилго нь ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ.
2. Намрын сорилгын бодлого даалгавар, хариултын хуудсыг Оюуны чадварын IQ төв боловсруулан аймаг болон дүүргийн/ сургуулиудын/ зохион байгуулах комисст хүргүүлнэ.
3. Уралдааны сэдвийг 2018 оны 10-р сарын 24-ны өдөр задлана.
4. Намрын сорилгыг зохион байгуулсан сургуулийн комисс сорилгод оролцогчдын хариултын хуудсыг шифрлэн, анги ангиар нь ангилан битүүмжилж, тоог хавсарган 2018 оны 11-р сарын 05-ны дотор Оюуны чадварын IQ төв (УБ хот, ГХЯамны баруун талын Гранд оффис төвийн 7 давхар)-д хүргүүлнэ.
5. Шифрлэж нэгтгэсэн файлыг 11-р сарын 01-ний дотор tugsuu@iqcenter.mn, azbileg@iqcenter.mn и-мэйл хаяг руу илгээнэ.

Анхаарах зүйл

1. i) Хариултын хуудсыг зааврын дагуу бөглөж, тасархай шугамаар таслан авч хураана.
ii) Зааврын дагуу хариултын хуудас бүрийг шифрлэнэ.
iii) Шифрлэлтийг зааврын дагуу Excel-ийн файл болгон нэгтгээд файлаа tugsuu@iqcenter.mn, azbileg@iqcenter.mn и-мэйл хаяг руу илгээнэ.
iv) Хариултын хуудсыг анги ангиар нь ангилан битүүмжилж IQ төвд илгээнэ.
2. Шифрлэлтийг зааврын дагуу гүйцэтгэнэ. Оюуны чадварын IQ төв нь зөвхөн шифрлэсэн хариултын хуудас болон тухайн шифрлэсэн файлыг email-ээр ирүүлсэн анги, сурагчдын материалыг засна. Бусад тохиолдолд засалт хийх боломжгүйг анхаарна уу!
3. Цагийг чанд баримталж, сорилгыг үнэнч шударгаар явуулна. I ангийн багшийн зааврыг анги бүрээр хувилан олшруулна. Сорилгын материал, хариултын хуудсыг хувилж олшруулж болохгүй.

№		Ангилал								
		I анги	II анги	III анги	IV анги	V анги	VI анги	VII анги	VIII анги	IX анги
1	Бодолтыг гүйцэтгэх хугацаа / мин/	40	40	40	40	40	40	40	40	40
2	Тестийн материал	A4-3+1 тал	A4-3 тал	A4-3 тал	A4-3 тал	A4-3 тал	A4-3 тал	A4-3 тал	A4-3 тал	A4-3 тал

Намрын сорилгыг дүгнэх

1. Нийт оролцогчдын бодолт засалт, оноо тооцолтыг Оюуны чадварын IQ төв гүйцэтгэнэ.
2. Сорилгод оролцсон сурагчдыг ангилал тус бүрт эхний ТОП 5%-д шалгарсан сурагчдыг тодруулан батламж олгоно.
3. Нийт оролцогчдын дүн мэдээ, онооны жагсаалтыг улсын хэмжээнд нэгтгэж, улмаар www.iqcenter.mn сайтад аймаг, дүүргээр нь ангилан оруулах бөгөөд сурагчид нь өндөр амжилт гаргасан аймаг, дүүрэг, сургуулийг шалгаруулж, батламж гардуулан мэдээллийн хэрэгслээр сурталчилна.
4. Сургууль, анги бүрээр сурагчдын дүн мэдээг гарган батламжийн хамт сургуулиудад IQ төвөөс хүргүүлнэ.

Холбоо барих:

Харилцах утас: 324342, 99742282, 99076010

E-mail: tugsuu@iqcenter.mn, azbileg@iqcenter.mn, Web site: www.iqcenter.mn

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Жамьян гүний гудамж-12, Гранд Оффис центр /Гадаад харилцааны яамны баруун талд, Сүхбаатарын талбайн урд/, 72 тоот.